

“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 дүгээр сарын
28- ны өдөр

Дугаар 01.17

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйл, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.17 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 2888255 санал буюу ердийн олонхийн 99.99%-ийн саналаар Компанийн 2016 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайлан, Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ -өөс өгсөн дүгнэлтийг тус тус баталсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ТУЗ-д ажлаа дүгнүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д үүрэг болгосугай.


Хурлын дарга

Д.Мөнхбат

Тооллогын комиссын дарга

Ч.Энхцэцэг





“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 дүгээр сарын
28-ны өдөр

Дугаар 02.17

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгох
тухай.

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.17 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын кумулятив 2887979 санал буюу 16,66%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, кумулятив 2887973 санал буюу 16,66%-ийн саналаар Д.Гиваапилыг, кумулятив 2887832 санал буюу 16,66%-ийн саналаар Д.Мөнхбатыг, кумулятив 2887973 санал буюу 16,66%-ийн саналаар С.Алимааг, кумулятив 2887975 санал буюу 16,66%-ийн саналаар, Ёндонжамцыг, кумулятив 2887973 санал буюу 16,66%-ийн саналаар Х.Ханияг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр,

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын кумулятив 2887746 санал буюу 33,33%-ийн саналаар Б.Болдыг, кумулятив 2887755 санал буюу 33,33%-ийн саналаар Б.Аюушийг, кумулятив 2887743 санал буюу 33,33%-ийн саналаар Э.Бямбажавыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр тус тус сонгосныг баталсугай.

3. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (С.Мөнхжаргал) - д зөвшөөрсүгэй.


Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Д.Мөнхбат

Ч.Энхцэцэг



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 дүгээр сарын
28-ны өдөр

Дугаар 03.17

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах
тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, Компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01.17 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.17 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01.17 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 5-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 2888244 санал буюу ердийн олонхийн 99,99%-ийн саналаар 2016 оны ашгаас нэгж хувьцаанд 17.82 төг, буюу нийт 62.1 сая.төг(жаран хоёр сая нэг зуун мянган)-ийг ногдол ашигт хуваарилсугай.

2. 2015 оны ногдол ашигт 114.8 сая.төг (нэг зуун арван дөрвөн сая найман зуун мянган), 2016 оны ногдол ашигт 62009.8 мян.төг (жаран хоёр сая есөн мянга найман зуун), нийт (114.8 сая.төг + 62.1 сая.төг) 176809.8 мянган төгрөг (нэг зуун далан зургаан сая найман зуун есөн мянга найман зуун)-ийг компанийн хуримтлагдсан ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д зөвшөөрсүгэй.

3. Компанийн мөнгөн гүйлгээний боломжтой үед зохицуулан 2015, 2016 оны ногдол ашгийг нийтэд зарлах хугацааны саналаа ТУЗ-д оруулж шийдвэрлүүлэн хувьцаа эзэмшигчдэд 2017 ондоо багтаан тараах ажлыг гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д даалгасугай


Хурлын дарга

Тооллогын комиссын дарга

Д.Мөнхбат

Ч.Энхцэцэг





“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 дүгээр сарын
22- ны өдөр

Дугаар 04.17

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 63.1.13-дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.17 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01.17 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 2888244 санал буюу ердийн олонхийн 99.99%-ийн саналаар компанийн ТУЗ-ийн 2017 оны зардлын төсөвийг 52298.0 мянган төгрөг (тавин хоёр сая хоёр зуун ерэн найман мянган) өөр баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга (С.Мөнхжрагал) –д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга

Д.Мөнхбат

Ч.Энхцэцэг

